

**ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1.	Аудитын гэрчилгээ	2
2.	Аудитын тайлан	4
2.1.	Оршил	4
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	6
2.9.	Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	8
2.9.1	Мөнгөн хөрөнгө	8
2.9.2	Авлага	9
2.9.3	Бараа материал	9
2.9.4	Үндсэн хөрөнгө	10
2.9.5	Өр төлбөр	10
2.9.6	Засгийн газрын хувь оролцоо	11
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	11
2.11.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	12
2.12.	Шилэн дансны мэдээлэл	12
2.13.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	12
2.14.	Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	12
3.	Менежментийн захидал	13
3.1	Харьяа газруудад илэрсэн зөрчилд зөвлөмж өгөх	13
4.	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	14
4.1	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	14
4.2	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	14
4.3	Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	15
4.4	Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	16
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	16
4.6	Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	17
5.	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
СХЗГ	Стандарт, хэмжил зүйн газар

1. Аудитын гэрчилгээ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2020.03.25 № 01/936
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН
ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.БИЛГҮҮН
ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Стандарт, хэмжил зүйн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Стандарт, хэмжил зүйн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн нэгтгэсэн тайланг материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Стандарт, хэмжил зүйн газрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10.20\Bichig_Kherreg\Yawsan_Bichig\2020\0325SAG12.Docx

001051684

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлсэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



О.ТЭНГИС

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Стандарт, хэмжил зүйн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Б.Билгүүн Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн харьяа байгууллагуудад илэрсэн зөрчлийг арилгах, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Стандарт, хэмжил зүйн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Стандарт, хэмжил зүйн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 3 дугаар сарын 05-наас 2020 оны 3 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 3 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Б.Сэржмядаг, аудитор А.Даваадорж, гэрээт ажилтан Н.Нямсүрэн нар гүйцэтгэв.

Стандарт, хэмжил зүйн газар 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 3 дугаар сарын 05-ны өдрийн 01/199 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе

шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

2.4. БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Монгол Улсын хөгжлийн стратеги, чиг хандлагад нийцүүлэн улс орон, нийгэм, эдийн засгийн аюулгүй байдлыг хангаж, экспортыг нэмэгдүүлж, үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд стандартчилал, хэмжил зүй, тохирлын үнэлгээ, сорьцын хяналтын бодлогоор дэмжлэг үзүүлэхэд оршино.

Стандарт, хэмжил зүйн газар нь 2019 онд дараах үр дүнд хүрэх зорилт тавьж хэрэгжүүлэн ажилласан байна. Үүнд:

- Төрийн захиргааны удирдлагыг хэрэгжүүлэх, зохицуулалтыг хангах, гадаад харилцаа, хамтын ажиллагааг эрхэлсэн асуудлаараа олон улс бүс нутаг, гадаад орны хүрээнд өргөжүүлэх;
- Стандартчилал, тохирлын үнэлгээ, хэмжлийн нэгдмэл байдлыг хангах хууль тогтоомжийг боловсронгуй болгоход санал боловсруулах, бодлого, стратегийг төлөвлөх, бодлогын удирдамжаар хангах, хэрэгжилтийг зохицуулах, гүйцэтгэлд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх;
- Стандартчилал, тохирлын үнэлгээ, техникийн зохицуулалтын хөтөлбөр, төсөл боловсруулах, техникийн зохицуулалтыг олон улсын жишгээр бий болгоход дэмжлэг үзүүлэх, тэдгээрийн төсөлд шүүлт хийх, эдгээр чиглэлийн дүрэм, журам, заавар, удирдамжаар хангах;
- Хэмжлийн нэгжийн олон улсын системд тулгуурласан үндэсний эталоны тогтолцоог хөгжүүлэх, нарийвчлалыг олон улсын түвшинд ойртуулах, үндэсний эталоноос нэгж дамжуулах тогтолцоог сайжруулан бэхжүүлэх;
- Итгэмжлэлийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, зохицуулалтыг хангах, олон улсын итгэмжлэлийн байгууллагаар итгэмжлүүлэх;
- Сорьцын хяналтын тогтолцоог боловсронгуй болгох, сорьцын лабораторийн чадавхыг дээшлүүлэх
- Олон улсын гэрээ хэлэлцээр, олон улс, бүс нутаг, гадаад орны болон үндэсний стандарт, тохирлын үнэлгээ, техникийн зохицуулалт болон холбогдох норматив техникийн баримт бичгээс бүрдсэн үндэсний мэдээллийн сан бүхий төрийн мэдээллийн нөөц болох албыг байгуулан хөгжүүлэх;
- Бүтээгдэхүүн үйлчилгээ, тогтолцооны баталгаажуулалтыг олон улсын жишигт хүргэж, хөгжүүлэх;
- Хэмжих хэрэгслийн баталгаажуулалтыг улсын баталгаажуулалтад заавал хамрагдах хэмжих хэрэгслийн баталгаажуулалтын түвшнийг дээшлүүлэх, баталгаажуулалтын ажлын чанарыг олон улсын түвшинд ойртуулах.

Стандарт, хэмжил зүйн газрын удирдлага төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Хэмжил зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулга
- Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Стандарт, хэмжил зүйн газрын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2018 онд холбогдох стандарт, журмын дагуу шинэчлэн боловсруулсан байна.

Стандарт, хэмжил зүйн газрын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

Стандарт, хэмжил зүйн газрын Хууль зүй, мониторингийн хэлтсийн 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө болон хэрэгжилттэй танилцахад 9 нэгжид хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхээр төлөвлөсөн боловч 5 нэгжийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн байна. Илрүүлсэн зөрчил байхгүй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Стандарт, хэмжил зүйн газрын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад, дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 15 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 15 асуудалд нарийвчилсан горим, сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшнийг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг Стандарт, хэмжил зүйн газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 11,056.2 сая төгрөгийн 2 хувь буюу 221.1 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг АОУС 320-д заасны дагуу тайлант жилийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 11,497.3 сая төгрөгийн 2 хувь буюу 229.9 сая төгрөгөөр тогтоосон болно.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд эрхлэх асуудлын хүрээний 21 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 17 байгууллагын санхүүгийн тайлан аудитад хамрагдсан, 4 байгууллагад итгэл үзүүлсэн.

Аудитад хамрагдсан 16 байгууллагын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” дүгнэлт, Ховд аймгийн стандарт хэмжил зүйн газрын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн байна.

Стандарт, хэмжил зүйн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 4,574.0 сая төгрөгийн 66 алдаа, зөрчил илрүүлснээс 4,379.5 сая төгрөгийн 13 алдааг аудитын явцад залруулж, 3.9 сая төгрөгийн зөрчилд 10 төлбөрийн акт тогтоож, 163.8 сая төгрөгийн зөрчлийг арилгах 17 албан шаардлага хүргүүлж, 26.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 26 зөвлөмжийг хүргүүллээ.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын явцад дараах алдаануудыг залруулсан. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд 1,048.6 сая төгрөг, Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайланд 1,089.6 сая төгрөг, Нэгтгэсэн нэмэлт санхүүжилтийн тайланд 352.3 сая төгрөг, нийт 2,526.5 сая төгрөгийг харьяа байгууллага хооронд устгах бичилт хийгээгүй;
- Хэнтий аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дуусаагүй хөрөнгө оруулалтын ажлын өмнөх оны үлдэгдэл 346.0 сая төгрөг, тайлант оны санхүүжилт нийт 380.0 сая төгрөг нийт 726.0 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын ажил дуусаагүй, ашиглагч байгууллагад хүлээлгэн өгөөгүй байхад дуусаагүй барилга байгууламж дансанд шилжүүлэн бүртгэсэн;
- Дорнод аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн барилгын хөрөнгө оруулалтын санхүүжилт болох 400.0 сая төгрөгийг эрх шилжүүлэх гүйлгээгээр ашиглагч байгууллагад шилжүүлснийг захиалагч талд хуримтлуулан бүртгээгүй;
- Үндсэн үйл ажиллагааны орлогыг 7.3 сая төгрөгөөр, нэмэлт орлогыг 2.2 сая төгрөгөөр тус тус илүү илэрхийлсэн, орлогын ангилал зөрүүтэй бүртгэсэн, эрх шилжүүлсэн хөрөнгийн санхүүжилт 400.0 сая төгрөгийг үр дүнгийн тайланд тусгаагүй;
- Барилга байгууламжийн элэгдлийн зардлыг 16.0 сая төгрөгөөр илүү, бусад хөрөнгийн элэгдлийн зардлыг 9.9 сая төгрөгөөр дутуу тооцоолсон;
- Стандарт, хэмжил зүйн газрын биет хөрөнгийн дансанд 129.8 сая төгрөгийн өртөгтэй газрыг бүртгэсэн;
- Говь-Алтай аймгийн Засаг даргын Тамгын газраас 4.5 сая төгрөгийн өртөгтэй машин, тоног төхөөрөмж, Баян-Өлгий аймгийн Засаг даргын Тамгын газраас 0.5 сая төгрөг, нийт 5.0 сая төгрөгийг хандив дансаар бүртгэсэн байсныг залруулж үнэ төлбөргүй хүлээн авсан орлого дансанд бүртгүүлсэн;
- Ховд аймгийн Өмчийн өөрчлөлтийн тайлангийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт дансанд программын алдаа 30.1 сая төгрөг бүртгэсэн.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар харьяа байгууллагуудын алдаа, зөрчлийг арилгуулахаар өгсөн 1 зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 1,882.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 1,688.2 сая төгрөгийн 9 алдааг аудитын явцад залруулж, 3.9 сая төгрөгийн 10 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 163.8 сая төгрөгийн 17 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 26.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 26 зөвлөмжийг хүргүүллээ.

2.9 САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

2.9.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 5.1 сая, эцсийн үлдэгдэл 2.7 сая төгрөг болж, 2.4 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа бэлэн мөнгө	5.1	2.7	-2.4
Дүн	5.1	2.7	-2.4

Эх сурвалж: Стандарт, хэмжил зүйн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 2.7 сая төгрөг Дундговь аймгийн ахмадын сангийн дансанд байршиж байна.

Аудитын илрүүлэлт:

- Цалин, нийгмийн даатгалын шимтгэл, хоол, унаа болон үр дүнгийн урамшуулалтай холбоотой 40.9 сая төгрөгийн зөрчил гарсан; /Завхан 0.1 сая, Дорнод 0.4 сая, Говь-Алтай 1.7 сая, Сэлэнгэ 0.8 сая, Дундговь 0.8 сая, СХЗГ 37.1 сая төгрөг/
- Баянхонгор аймгийн стандарт, хэмжил зүйн газар тайлант онд үндсэн бус үйл ажиллагаанаас орсон 29.6 сая төгрөгөөс 26.9 сая төгрөгийг Стандарт, хэмжил зүйн газраас өгсөн чиглэлийн дагуу хэлтсийн даргад олгосон;
- Говь-Алтай аймгийн стандарт, хэмжил зүйн газар 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 11.3 сая төгрөгийн төлбөрийн акт, 1.5 сая төгрөгийн албан шаардлагын үлдэгдэлтэй;
- Анхан шатны баримтын бүрдэл дутуу 12.4 сая төгрөгийн гүйлгээ хийсэн; /Төв 5 сая, Ховд 7.4 сая төгрөг/
- Томилолтын зардлыг Сангийн сайдын 2018 оны 301 дүгээр тушаалаар баталсан зардлын хэмжээнээс хэтрүүлсэн болон дутуу олгосон 6.2 сая төгрөгийн зөрчил гарсан; /Архангай 5.6 сая, Завхан 0.1 сая, Говь-Алтай 0.5 сая төгрөг/
- Нийслэл дэх Төрийн аудитын газраас 2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 2.4 сая төгрөгийн актыг төсвөөс төлсөн, Нэмэлт санхүүжилтийн данснаас тушаал шийдвэргүй 15 ширхэг 0.3 сая төгрөгийн бэлэг авч баримтгүй зарцуулсан;
- Булган аймгийн стандарт, хэмжил зүйн газар өөрийн үйл ажиллагааны 1.3 сая төгрөгийн орлогыг бэлнээр хураан авч, тухай бүр төвлөрүүлээгүй, 1,304.7 сая төгрөгийг бүлэг хооронд шилжүүлэн зарцуулсан, нэмэлт санхүүжилтийн шатахууны зардалд 1,647.7 сая төгрөгийг эдийн засгийн ангиллын дагуу эрх нээлгээгүй шалтгаанаас мөнгөн гүйлгээний тайланд бусад бараа үйлчилгээний зардалд бүртгэсэн;
- Дундговь аймгийн стандарт, хэмжил зүйн газар хүчингүй болсон журмын заалт үндэслэн төсөв захиран зарцуулсан;
- Тээвэр шатахууны зардлыг автомашины 100км гүйлтэд зарцуулах шатахууны норм, нормативаас 2.9 сая төгрөгөөр хэтрүүлэн, зориулалт бусаар зарцуулсан; /Дархан Уул 0.7 сая, Булган 0.4 сая, Дорнод 1.6 сая, Говь-Алтай 0.2 сая төгрөг/
- Дундговь аймгийн стандарт, хэмжил зүйн газар төвлөрсөн халаалттай орон сууцанд байдаг ажилтанд түлээ нүүрсний мөнгө 1.8 сая төгрөг олгосон.

2.9.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 148.7 сая, эцсийн үлдэгдэл 170.9 сая төгрөг болж, 22.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -
Ажиллагчидтай холбогдсон авлага	9.3	19.0	9.7
Төлбөртэй үйлчилгээний авлага	82.9	86.0	3.1
Татаас, санхүүжилтийн авлага	37.7	8.1	-29.6
Бусад авлага	18.8	57.8	39.0
Дүн	148.7	170.9	22.2

Эх сурвалж: Стандарт, хэмжил зүйн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны үлдэгдэл өссөн нь Стандарт, хэмжил зүйн газрын нягтлан бодогчид 12 дугаар сард данс андуурч хувь хүний орлогын албан татварын 12.6 сая төгрөгийг нийгмийн даатгалын шимтгэлийн дансанд шилжүүлсэн, дотоод хяналт шалгалтаар үнэт цаас дутагдаж холбогдох мэргэжилтнүүдээр буцаан төлүүлэхээр 5.2 сая төгрөгийн авлага үүсгэн бүртгэсэн зэргээс голлон шалтгаалжээ.

Аудитын илрүүлэлт:

Төсвийг зохистой удирдаж чадаагүйгээс авлага үүсгэсэн, тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулаагүй 29.8 сая төгрөгийн зөрчил гарсан байна. /Завхан 0.4 сая, Сэлэнгэ 1.3 сая, Говь-Алтай 2.4 сая, Ховд 11.1 сая, СХЗГ 14.6 сая төгрөг/

Стандарт, хэмжил зүйн газар үндсэн үйл ажиллагаатай холбоотой орлогуудаас хэмжих хэрэгсэл шалгалт баталгаажуулалтын орлого, итгэмжлэлийн орлогыг түүвэрт хамруулан анхан шатны баримт руу хөөн шалгахад 96.6 сая төгрөгийг авлагаар бүртгээгүй байна.

2.9.3 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 746.9 сая, эцсийн үлдэгдэл 1,564.7 сая төгрөг болж, 817.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -
Тусгай зориулалттай материал	184.4	207.7	23.3
Эм боох материал	7.5	11.7	4.2
Дуусаагүй үйлдвэрлэл	346.0	1,126.0	780.0
Бэлэн бүтээгдэхүүн	43.2	42.9	-0.3
Хангамжийн материал	164.3	176.4	12.1
Мал амьтад	1.6	0.0	-1.6
Дүн	747.0	1,564.7	817.7

Эх сурвалж: Стандарт, хэмжил зүйн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдэл 817.8 сая төгрөгөөр өссөн нь 2 аймгийн стандарт, хэмжил зүйн хэлтсийн барилгын дуусаагүй хөрөнгө оруулалт 780.0 сая төгрөг, тусгай зориулалтын хангамжийн материал 19.5 сая төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Аудитын илрүүлэлт:

Стандарт хэмжил зүйн газар лабораторийн зарцуулагдаагүй үлдсэн 6943 ширхэг 1.0 төгрөгийн үнэт цаасыг зарцуулснаар тайлагнасан;

Булган аймгийн стандарт, хэмжил зүйн газар санхүүгийн тайлан, бараа материалын тодруулга тайлан дахь аж ахуйн материалын дүн жилийн эцсийн тооллогын дүнгээс 1.5 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан;

Дорнод аймгийн стандарт, хэмжил зүйн газар анхан шатны баримт дутуу 31.5 сая төгрөгийн худалдан авалт хийсэн байна.

2.9.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 11,953.9 сая, эцсийн үлдэгдэл 12,004.7 сая төгрөг болж, 50.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -
Барилга, байгууламж, орон сууц	3,891.9	3,533.3	-358.6
Авто-тээврийн хэрэгсэл	92.7	123.8	31.0
Машин тоног төхөөрөмж(компьютер)	1,143.0	1,010.7	-132.3
Тавилга, аж ахуйн эд хогшил	129.6	122.4	-7.2
Зам, гүүрийн байгууламж	0.0	3.5	3.5
Бусад үндсэн хөрөнгө	47.2	47.6	0.5
Ном	6.1	6.2	0.0
Биет хөрөнгө	5,310.5	4,847.4	-463.1
Програм хангамж	8.3	136.6	128.3
Бусад биет бус хөрөнгө	444.7	444.7	0.0
Дүн	5,763.5	5,428.7	-334.8

Эх сурвалж: Стандарт, хэмжил зүйн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь тайлант оны элэгдлийн зардал 670.4 сая төгрөг байгуулснаас голлон шалтгаалжээ. Мөн туслах үйл ажиллагааны орлогоос 93.0 сая төгрөг, Герман улсын Физик технологийн хүрээлэнгийн буцалтгүй тусламжаар эталон тусгай зориулалтын тоног төхөөрөмж 105.1 сая төгрөг, өмнөх оны авлагаас 7.7 сая төгрөг, нийт 205.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн байна.

Харин барилга байгууламж дансанд өмнөх оны дахин үнэлгээгээр 129.8 сая төгрөгөөр үнэлэгдсэн газар эзэмших эрхийг бүртгэснийг аудитын хугацаанд холбогдох журмын дагуу биет бус хөрөнгө дансанд шилжүүлэн бүртгэснээс шалтгаалан бусад биет бус хөрөнгө нэмэгдсэн.

Аудитын илрүүлэлт:

- *Стандарт, хэмжил зүйн газрын төв байрны газар эзэмших гэрчилгээний хугацаа 2016 онд дууссан, байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд 2009 оноос хойш өөрчлөлт оруулаагүй;*
- *Стандарт, хэмжил зүйн газрын ашиглаж байгаа санхүүгийн программ хангамж нь "нягтлан бодох бүртгэлийн программд тавигдах шаардлага"-ыг хангаагүй;*
- *Төв аймгийн эзэмшилд байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 28.9 сая төгрөгийн 24 ширхэг хөрөнгийг дахин үнэлж бүртгэлд тусгаагүй, үлдэх өртөгтэй элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхөөгүй 0.1 сая төгрөгийн хөрөнгө акталсан;*
- *Булган аймаг программ хангамжид хорогдол тооцоогүй;*
- *Говь-Алтай аймгийн стандарт, хэмжил зүйн газар элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 45 төрлийн 50.1 сая төгрөгийн өртөг бүхий үндсэн хөрөнгө бүртгэлтэй;*

2.9.5 Өр төлбөр

Стандарт, хэмжил зүйн газрын нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 18.1 сая, эцсийн үлдэгдэл 32.6 сая төгрөг болж, 14.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -
Ажилчидтай холбогдсон өглөг	3.8	3.6	-0.3
Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.1	2.3	2.2
Бусад өглөг	13.5	26.3	12.8
Урьдчилж орсон орлого	0.7	0.5	-0.2
Дүн	18.1	32.6	14.5

Эх сурвалж: Стандарт, хэмжил зүйн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр дансны үлдэгдэл 14.5 сая төгрөгөөр өссөн нь 12 дугаар сард данс андуурч хувь хүний орлогын албан татварын 12.6 сая төгрөгийг нийгмийн даатгалын шимтгэлийн дансанд шилжүүлснээс татварын өглөгтэй гарсан нь голлон нөлөөлсөн байна.

Аудитын илрүүлэлт:

- Төсвийг зохистой удирдаж чадаагүйгээс тайлант онд өр төлбөр үүсгэсэн, тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулаагүй 30.5 сая төгрөгийн зөрчил гарсан. /Говь-Алтай 3.9 сая, Сэлэнгэ 26.6 сая төгрөг/

2.9.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 6,652.5 сая, эцсийн үлдэгдэл 7,141.5 сая төгрөг болж, 489.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №6. Засгийн газрын хувь оролцоо /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт /-/
Засгийн газрын оруулсан капитал	6,180.9	6,180.9	0.0
Хуримтлагдсан үр дүн	-1,587.0	-1,098.0	489.1
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,058.6	2,058.5	-0.1
Дүн	6,652.5	7,141.5	489.0

Эх сурвалж: Засгийн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо данс 489.0 сая төгрөгөөр өссөнд тайлант жилийн үр дүн нөлөөлсөн байна.

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн төвлөрүүлэн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 6,967.7 сая төгрөгийн төсөв батлагдсанаас урсгал зардалд 6,187.7 сая төгрөг, хөрөнгө оруулалтын санхүүжилтэд 780.0 сая төгрөг зарцуулахаар төсөвлөсөн байна. Нийт зардлын 6,907.7 сая төгрөгийг Улсын төсвөөс, 60.0 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 6,841.9 сая төгрөгийг олгож, 6,785.1 сая төгрөгийг зарцуулж 99.18 хувийн биелэлттэй, 56.8 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Үндсэн үйл ажиллагааны орлого 68.9 сая төгрөгийг бүрдүүлж, төлөвлөгөөг 8.9 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Стандарт, хэмжил зүйн газар 383 орон тоотой ажиллахаас 382 орон тоогоор ажилласан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт төсөв: Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд ЗГНХ, ЗДНХөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 67.1 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 353.5 сая төгрөг нийт 420.6 сая төгрөг төвлөрсөн.

Үүнээс бараа, ажил үйлчилгээний зардалд 239.7 сая, хөрөнгийн зардалд 72.0 сая төгрөг, урсгал шилжүүлэгт 68.8 сая төгрөгийг зарцуулж, 44.3 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Стандарт, хэмжил зүйн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй болно.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Стандарт, хэмжил зүйн газар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн оруулан ажилласан байна.

2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1.8 сая төгрөгийн 2 төлбөрийн акт, 312.6 сая төгрөгийн 5 албан шаардлага, 85.3 сая төгрөгийн 5 зөвлөмж өгснийг 90 хувь хэрэгжүүлж ажилласан байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Стандарт, хэмжил зүйн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Стандарт, хэмжил зүйн газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Стандарт, хэмжил зүйн газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Харьяа газруудад илэрсэн зөрчилд зөвлөмж өгөх

3.2.1 Илрүүлэлт:

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа байгууллагуудын 21 санхүүгийн тайлангийн аудитаар нийт 1,882.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 1,688.2 сая төгрөгийн 9 алдааг аудитын явцад залруулж, 3.9 сая төгрөгийн 10 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 163.8 сая төгрөгийн 17 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 26.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 26 зөвлөмжийг хүргүүлсэн.

3.2.2 Эрсдэл:

Эрх ба үүрэг батламж мэдэгдэл хангагдаагүй, дээд шатны удирдлагын дотоод хяналт сул байх.

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Харьяа газруудад өгсөн зөвлөмж, албан шаардлага, актын биелэлтийг хэрэгжүүлэн ажиллахад хяналт тавих, зөрчлийг давтан гаргуулахгүй байхад анхаарч ажиллах.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2020 оны 9 дүгээр сарын 10-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2018оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
		/мянган төгрөг/	
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	907,133.1	1,745,401.0
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	5,147.7	2,699.1
33	АВЛАГА	148,724.7	170,911.4
35	БАРАА МАТЕРИАЛ	746,986.7	1,564,716.5
36	НӨӨЦИЙН БАРАА	6,274.0	7,074.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,763,473.4	5,428,692.6
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,763,473.4	5,428,692.6
39200	Биет хөрөнгө	5,310,487.1	4,847,428.5
39300	Биет бус хөрөнгө	452,986.3	581,264.1
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	6,670,606.5	7,174,093.6
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	18,111.3	32,624.2
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	18,111.3	32,624.2
41300	Өглөг	17,455.8	32,164.2
41400	Урьдчилж орсон орлого	655.5	460.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,652,495.2	7,141,469.4
51	Засгийн газрын хувь оролцоо	6,652,495.2	7,141,469.4
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	6,180,931.6	6,180,931.6
51200	Хуримтлагдсан үр дүн	-1,587,044.8	-1,097,967.6
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,058,608.4	2,058,505.4
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	6,670,606.5	7,174,093.6

4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2018оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
		/мянган төгрөг/	
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	12,233,098.9	11,985,184.5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,811,306.9	5,068,501.1
120	Нийтлэг татварын бус орлого	4,811,306.9	5,068,501.1
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	7,421,792.0	6,916,683.4
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	11,948,533.2	11,492,007.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	11,948,533.2	11,492,007.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,915,570.0	6,238,856.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,451,648.1	3,895,070.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	411,070.6	486,746.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	324,030.6	328,132.2
2104	Хангамж, бараа материалын зардал	226,793.0	201,131.8
2105	Нормативт зардал	108,352.1	104,459.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	255,904.4	50,450.5
2107	Томилолт, зочны зардал	191,144.8	176,442.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	154,340.5	194,443.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	792,285.8	801,979.2

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,032,963.2	5,253,151.2
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	284,565.7	493,177.1
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	65.0	1,553.0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	112,110.0	5,249.1
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	172,520.8	489,481.0

4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2018оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	12,034,161.4	11,466,286.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,614,965.0	4,537,702.9
120	Нийтлэг татварын бус орлого	4,614,965.0	4,537,702.9
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	7,419,196.4	6,928,583.6
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	11,543,674.7	10,890,294.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	11,543,674.7	10,890,294.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,433,675.7	5,623,668.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,447,413.6	3,903,950.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	415,877.0	485,537.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	344,176.0	318,349.3
2104	Хангамж, бараа материалын зардал	209,893.2	168,789.8
2105	Нормативт зардал	129,991.7	104,618.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	302,992.2	74,412.3
2107	Томилолт, зочны зардал	201,231.1	168,566.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	205,459.5	255,329.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	176,641.6	144,114.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,109,999.0	5,266,626.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	490,486.7	575,992.5
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	489,763.5	578,441.1
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	489,763.5	578,441.1
2200	Дотоод эх үүсвэрээр	489,763.5	578,441.1
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-489,763.5	-578,441.1
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	723.2	-2,448.6
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,424.5	5,147.7
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5,147.7	2,699.1

4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,313,756.7	5,313,756.7
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	1,261.3	1,261.3
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,315,018.0	5,315,018.0
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	716,408.0	716,408.0
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	448,548.4	448,548.4
9	Тайлант үеийн үр дүн	172,520.8	172,520.8
10	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,652,495.2	6,652,495.2
11	2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	6,652,495.2	6,652,495.2
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-403.8	-403.8
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,652,091.3	6,652,091.3
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-103.0	-103.0
19	Тайлант үеийн үр дүн	489,481.0	489,481.0
20	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,141,469.4	7,141,469.4

/мянган төгрөг/

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,967,679.1	6,910,833.6	56,845.5	99.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,187,679.1	6,130,834.6	56,844.5	99.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,513,952.9	5,507,828.9	6,124.0	99.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,903,054.8	3,896,549.3	6,505.5	99.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	485,550.1	484,749.4	800.7	99.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	308,827.9	315,401.0	-6,573.1	102.1
2104	Хангамж, бараа материалын зардал	166,863.4	166,504.2	359.2	99.8
2105	Нормативт зардал	89,910.4	89,910.4	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	69,936.1	69,913.4	22.7	99.9
2107	Томилот, зочны зардал	163,766.2	161,080.2	2,686.0	98.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	212,474.1	210,410.8	2,063.3	99.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	113,569.9	113,310.2	259.7	99.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	673,726.2	623,005.7	50,720.5	92.5
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	264,371.5	264,311.4	60.1	99.9

/мянган төгрөгөөр/

2132	Бусад урсгал шилжүүлэг	409,354.7	358,694.3	50,660.4	87.6
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	780,000.0	779,999.0	1.0	100.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	6,967,679.1	6,910,835.0	56,844.1	99.2
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	6,907,679.1	6,841,886.2	65,792.9	99.0
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	60,000.0	68,948.8	-8,948.8	114.9
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	60,000.0	68,948.8	-8,948.8	114.9
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	21.00	21.00	0	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	383.00	382.00	1	99.7

4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/ ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	424,958.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	352,881.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	239,753.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	7,401.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	788.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,948.3
2104	Хангамж, бараа материалын зардал	2,852.0
2105	Нормативт зардал	14,982.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	121,192.1
2107	Томилот, зочны зардал	7,486.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	53,249.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	28,852.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	113,128.3
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	4,406.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	64,372.7
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	44,349.4
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	72,076.6
2200	Дотоод эх үүсвэрээр	72,076.6
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	72,076.6
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	420,552.2
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	420,552.2
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	67,100.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	353,452.2
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-4,406.2
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,406.2

5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа байгууллагуудын 21 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн ба үүнээс 16 санхүүгийн тайланд зөрчилгүй, 4 санхүүгийн тайланд итгэл үзүүлсэн, 1 санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн байна. аудитаар нийт 1,882.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 1,688.2 сая төгрөгийн 9 алдааг аудитын явцад залруулж, 3.9 сая төгрөгийн 10 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 163.8 сая төгрөгийн 17 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 26.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 26 зөвлөмжийг хүргүүлсэн.		Зөвлөмж өгөх		
	Нийт дүн				

